

БАТЛАВ
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН
2025 оны 09 дугаар сарын 30
АТЛ14401 9025010818 5890683

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 09 дүгээр сарын 30

Дугаар 08

Налайх дүүрэг

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурал 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 13:00 цагт Налайх дүүрэг 3 дугаар хороо, паркийн захиргааны байрны 201 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа /минут/	Асуудал танилцуулах албан тушаалтан	Гарах шийдвэр
1	2025 оны Архивын улсын үзлэгтэй холбоотойгоор архивын өрөөнд архивын тавиур авах тухай	30	Зөвлөлийн дарга	Тэмдэглэл

**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 09 дүгээр сарын 30

Дугаар 08

Налайх дүүрэг

Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 201 тоот хурлын танхимд 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 13:00 цагт эхэлж 13:30 цагт дуусгав.

Хуралд:

Дарга

Нарийн бичгийн дарга

Гишүүд

Н.Пүрэвсүрэн

О.Чулуун-Эрдэнэ

Г.Ганцэцэг

Б.Түмэнжаргал

Б.Болортуяа нар оролцов.

Хурлын ирц 100 хувь.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: 2025 оны Архивын улсын үзлэгтэй холбоотойгоор архивын өрөөнд архивын тавиур авах тухай

СОНССОН НЬ: 2025 оны Архивын улсын үзлэгт Архивын өрөөнд тавиур авч суурилуулах шаардлага үүссэн.

Н.Пүрэвсүрэн: 2025 оны Архивын улсын үзлэгийн удирдамж ирж шалгалт явуулах хугацаа товлөгджээ. 2025 оны 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд манай байгууллага Албан хэрэг хөтлөлт, архив, байгууллагын үндсэн үйл ажиллагаа чиглэлээр үзлэгт хамрагдана. Архивын өрөөнд нэн тэргүүнд баримт материалуудаа цэгцэлж тавих тавиур шаардлагатай, тэр нь бас үзлэгт нэг чухал үзүүлэлт болж орж ирдэг гэдгийг Захиргааны ажилтан бидэнд мэдэгдсэн. Иймд тавиур авах шаардлага үүссэн байна. Гишүүд саналаа хэлнэ үү.

Б.Болортуяа: За ойлголоо. Албан байгууллага бүрт заавал байх ёстой тавилга эд хогшил учраас худалдан авахад татгалзах зүйлгүй.

Г.Ганцэцэг: Төсвийн нөөц бололцоондоо тааруулаад тавиур авахад татгалзах зүйл байхгүй ээ. 2-3 байгууллагаас үнийн санал авсан. Хямд хэрнээ суурилуулж өгөх боломжтой газраа сонгоод захиалгаа өгөөд суурилуулаад авъя

О.Чулуун-Эрдэнэ: Саналгүй.

Б.Түмэнжаргал: Налайх дүүргээс ирж суурилуулж өгөх “Авзага хайрхан стар” ХХК-ийн тавиур их таалагдлаа. Энэ газраар хийлгэе.

Н.Пүрэвсүрэн: Гишүүд татгалзах саналгүй тул тус компианаар хийлгэе.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Авзага хайрхан стар” ХХК-иас

- Архивын тавиур – 880,000 төгрөг,

Нийт – 880,000 төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авахаар шийдвэрлэв.

- Тус хөрөнгийг хүлээн авч байгууллагын холбогдох дансанд бүртгэн авахыг Нярав Э.Ундармаад үүрэг болгов.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн

Дарга

Нарийн бичгийн дарга

Н.Пүрэвсүрэн /Ахлах мэргэжилтэн/

О.Чулуун-Эрдэнэ /ГХХА хариуцсан мэргэжилтэн/

